



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/02

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дугаар зүйлийн 34.1.1 дахь заалт, Засаг даргын тамгын газрын даргын 2017 оны А/07 тоот тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Аймгийн төвийн малчин хорооллын айл өрхүүдийн цахилгаан хангамжийг сайжруулах, дэд өртөө барих” ажил /ДУОНӨГ/2017/00002/-ын гүйцэтгэгчээр “Мон – Энержи Корпораци” ХХК – ийг сонгон 38,900,000 /гучин найман сая есөн зуун мянган/ төгрөгөөр гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу барилга угсралтын ажлыг чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг “Мон – Энержи Корпораци” ХХК-ний гүйцэтгэх захирал /Б.Өрнөхбаяр/ -д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, ажлын явцад гүйцэтгэлийн хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Сайнцагаан сумын Засаг дарга /Р.Мөнхтогтох/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



О.ЧУЛУУНБАТ

0200265